



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас/факс: (976-11) 329084  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2015.01.22 № 3/253.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Биелэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан Төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан салбарын үйл ажиллагаатай холбоотой тогтоол шийдвэрүүдийн биелэлтийг 2014 оны жилийн эцсийн байдлаар гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудас.

Хүндэтгэсэн,

ДАРГА



З.НАРАНТУЯА

00068

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2014 оны жилийн эцсийн байдлаар

| Д/Д | Тогтоол<br>шийдвэрийн огноо,<br>дугаар, нэр  | Засгийн газрын<br>тогтоол<br>2010.04.14.<br>Дугаар 95   | Засгийн газрын<br>тогтоол<br>2010.04.14.<br>Дугаар 95   | Тогтоол<br>2010.04.14.<br>Дугаар 95  | Тогтоол<br>2010.04.14.<br>Дугаар 95   | Хувь |
|-----|--|---|---|--|---|------|
| 1   | Монгол Улсын<br>Мянганы хөгжлийн<br>зорилтод суурилсан<br>Үндэсний хөгжлийн<br>цогц бодлогын<br>хэрэгжилтэд, эхний<br>шатын үнэлгээ хийх<br>төлөвлөгөө батлах<br>тухай | <p>5.1.3. Мөнгө зээлийн бодлого</p> <p>5.1.3.1. оновчтой төгрөгийн зохистой байлгана.</p> <p>Инфляцийг удирдах, ханшийг түвшинд</p> | <p>5.1.3.1.3. Хадгаламжийн даатгалын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх</p>   | <p>Хадгаламж зээлийн хоршоо бүрт “Хадгаламжийн даатгалын сан” байгуулж ажиллах талаар хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам”-д тусган 2014 оны 1 дүгээр сард баталж мөрдүүлээ. Хадгаламж зээлийн хоршоодыг хадгаламжийн даатгалд хамруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны төслийн олон улсын зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжийн дагуу судалгаа хийж, Хадгаламж зээлийн хоршоодын удирдах ажилтнууд болон нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад зориулсан бүсчилсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн “Гөрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн 3.5 дахь “Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг мөнгөн хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангана” гэсэн заалтыг тусгуулаад байна.</p> | <p>Хөрөнгийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн нийлүүлэх, түүнийг гадаад зах зээлд гаргахтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг Үнэт цаасны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д оруулсан. Дотоодын бүртгэлтэй компани өөрийн үнэт цаасыг давхар бүртгүүлэх замаар эсхүл хадгаламжийн бичиг /DR/ хэлбэрээр гадаадын хөрөнгийн бирж дээр гаргах боломжтой байх зохицуулалтын тухай журмыг баталсан. Монголбанкнаар дамжин арилжаалагдаж байгаа Засгийн</p> | 100  |
|     |  | <p>5.1.3.2. Банк санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгоно.</p>   | <p>5.1.3.2.4. Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаад зах зээлд гаргаж, хөрөнгийн гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх, Засгийн</p> |  |   | 100  |

газрын үнэт цаасны арилжааг, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлээр өргөтгөх

газрын үнэт цаасны арилжааг хөрөнгийн зах зээл рүү хандуулж "МХБ" ХХК-аар дамжуулан арилжаалж эхэлсэн. Засгийн газар, орон нутгийн болон компанийн өрийн хэрэгслийг Хөрөнгийн биржээр арилжаалах арга хэмжээний хүрээнд Хорооны 2014 оны "Засгийн газрын үнэт цаасыг бүртгэх тухай" 389 дүгээр тогтоолоор дотоодын үнэт цаасны зах зээл дээр нийтэд санал болгон гаргах нийт 100,0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Засгийн газрын өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн. Энэхүү үнэт цаас нь 2014 оны 11 сарын 04-ний өдрөөс эхлэн хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхлээд байгаа ба 11 сард 4 удаагийн арилжаагаар нийт 28 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын өрийн хэрэгсэл арилжаалагдаад байна.

Гадаадын үнэт цаасыг Монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг, Хорооны 2014 оны 6 дугаар сарын 25-ны 253 дугаар тогтоолоор "Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам"-ыг тус тус баталсан. Цаашид уг үнэт цаасыг хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн арилжаалах, түүний хадгалалт, төлбөр тооцооны тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.

ХАА-н бирж, ХАА-н биржийн зуучлагч (брокер)-ийн компануудад Компанийн засаглалын кодексийг нэвтрүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг нийт 15 Хөдөө аж ахуйн биржийн удирдлагыг 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан "Шинэчлэгдсэн компанийн засаглалын кодексийг таниулах сургалт"-нд хамруулсан. Мөн нэр бүхий 10 Хөдөө аж ахуйн биржид Компанийн засаглалын кодексийг хэрхэн нэвтрүүлж, мөрдөж байгаа байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг хийлээ.

2013 оны 10 сард батлагдан, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу нэр бүхий 12 активт хөрөнгө оруулах боломжтой болсон бөгөөд Хорооноос

|  |   |  |   |
|--|---|--|---|
|  |   |  | <p>2014 оны 08 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, 2014 оны 175 дугаар тогтоолоор “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, 2014 оны 254 дүгээр тогтоолоор “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ыг тус тус батлаад байна. Хууль, холбогдох журмууд багтагдсанаас хойш нийт 2 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийг Хорооноос авсан байна.</p> <p>“МИК” ХХК нь ипотекийн зээлийг багцлах замаар нэгтгэн үнэт цаасжуулах чиг үүрэг бүхий тусгай зориулалтын компани бөгөөд түүний үйл ажиллагаа жигдэрч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, арилжаалах ажиллагааг Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу амжилтай хэрэгжүүлж байна.</p> <p>Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг баталснаар Монгол Улсад эд хөрөнгө, шаардах эрх, орон сууцны урт хугацаат зээл, авлагаар баталгаажуулсан (үнэт цаасжуулсан) санхүүгийн бүтээгдэхүүн арилжаалагдах эрх зүйн боломж бүрдсэн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, оролцогч этгээдэд тусгай зөвшөөрөл олгох нөхцөлд, шаардлага, үйл ажиллагаанд тавих хяналт зэргийг дээрх хуулиар Хороо хэрэгжүүлэх ба энэ талаарх нарийвчилсан журам тогтоох чиг үүргийг олгосны дагуу уг харилцааг нарийвчлан зохицуулсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг баталсан. Журмын дагуу 2011 онд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Монголын Ипотекийн корпораци” ХХК-д олгосон.</p> <p>Монгол Улсын Засгийн газар “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг 2013.01.09-ний өдөр баталсан. Хөтөлбөрийг</p> |
|  | <p><b>5.1.3.2.5.</b><br/>Ипотекийн нэгтгэлийн үйл ажиллагааг жигдрүүлэх</p> |  |   |

хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “МИК ОССК” ХХК нь нийт 322.9 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийн багцыг арилжааны 9 банкаас шилжүүлэн авч, түүнд суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг өөрийн байгуулсан “МИК Актив Нэг” ХХК-аар дамжуулан гаргах тусгай зөвшөөрөл авахаар, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа бүртгүүлэхээр Хороонд хандсаныг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хянаж, 2013 оны 12 дугаар сард “МИК ОССК” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “МИК Актив Нэг” ХХК-д тусгай зөвшөөрөл тус тус олгож, “МИК Актив Нэг” ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн. 2014 оны 03 дугаар сард “МИК ОССК” ХХК нь хоёр дахь ээлжийн 437.4 тэрбум төгрөг хүртэлх нэрлэсэн үнэ бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор “МИК Актив Хоёр” ХХК-ийг үүсгэн байгуулж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл хүсч Хороонд хандсан. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу гаргаж буй 224,836,200,000 төгрөг хүртэлх нэрлэсэн үнэ бүхий ипотекийн зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас-ыг бүртгэж, “МИК Актив Хоёр” ХХК-д тусгай зориулалтын компанийн тусгай зөвшөөрөл олгох үсэлтийг шийдвэрлэв.

“МИК Актив Гурав ТЗК” ХХК-д Хорооны 2014.10.21-ний өдрийн 385 дугаар тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “МИК Актив Гурав ТЗК” ХХК-ийн гаргах 328,548,600,000 төгрөг хүртэлх баталгаат үнэт цаасыг Хорооны 2014.06.25-ны 386 дугаар тогтоолоор бүртгэсэн.

2014 онд “МИК Актив Нэг ТЗК” ХХК, “МИК Актив Хоёр ТЗК” ХХК болон тэдгээрийн хөрөнгө итгэмжлэн удирдагч “МИК ОССК” ХХК-уудын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

|  |  |   |  |  |
|--|--|---|--|--|
|  |  |   | <p><b>5.1.3.2.6.</b><br/>Банк, санхүүгийн байгууллагын зах зээлд суурилсан хяналт шалгалтын удирдлагыг боловсронгуй болгох</p> | <p>“Эрсдэлийн онол”, “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сургалтуудыг зохион байгуулж Хорооны хянан шалгагчдыг хамруулан учирч болох эрсдэлийг танин мэдэх, эрт анхааруулах систем, дотоод хяналтын хуудсыг нэвтрүүлэх чиглэлээр онолын мэдлэг олгов. “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх болон сургалтын MON/004” төслийн хүрээнд Бичил санхүүгийн газрын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга зүй, санхүүгийн байгууллагуудын эрсдэлийг тооцож бүртгэх болон эконометрикийн талаарх ерөнхий ойлголтыг бий болгож, түүнийг бодлого боловруулах, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаарх практик мэдлэгийг олгох зорилгоор “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан ба сургалтад нийт 100 албан хаагч хамрагдсан. Зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн улирал /сар/-ын санхүүгийн тайлан тэнцэл болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Fina системээр болон цаасан хэлбэрээр улирал бүр хүлээн авч хянан давхардсан тоогоор нийт 732 Банк бус санхүүгийн байгуулага, 534 Хадгаламж зээлийн хоршоодод хариу албан тоог илгээж үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлэн зайны хяналт тавин ажиллаж байна. 2014 онд 36 банк бус санхүүгийн байгуулага, 35 хадгаламж зээлийн хоршоо, Орон нутгийн 15 хадгаламж зээлийн хоршоонд газар дээрх шалгалтыг явууллаа. Нийт 9 аймгийн 26 хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд газар дээр нь очиж танилцан зөвлөх үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>2014 онд зохицуулалтын салбарын 7 мэргэжлийн холбоотой харилцан хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Санамж бичгийн хүрээнд зохицуулалтын хүрээний байгууллагуудад сургалт зохион байгуулах, хамтарсан шалгалт хийх, удирдлагын мэдээллийн системээр хангах, гадаад орнуудын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаатай танилцах зэргээр хамтарч ажиллалаа. Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт</p> |
|  | <p><b>5.1.7.1.</b> Хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж бэхжүүлнэ.</p> | <p><b>5.1.7. Хувийн хэвшлийн хөгжил</b><br/><b>5.1.7.1.3.</b><br/>Хувийн хэвшлийн нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах</p> | <p>100</p>   |  |

|  |  |  |  |   |
|--|--|--|--|---|
|  |  |  |  | <p>бичгийн төслийг боловруулах ажлын хэсэгт орж ажиллан саналаа Эдийн Засгийн Хөгжлийн Яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Эрдэс Баялаг Түүхий Эдийн Иж Бүрэн Санаачлага төсөлд хүргүүллээ. Одоогоор бодлогын баримт бичгийн эхний хэлэлцүүлгийг төрийн байгууллагуудын хүрээнд зохион байгуулсан бөгөөд цаашид 4 цуврал хэлэлцүүлэг хийхээр төлөвлөн бэлтгэл ажил хийж байна.Түүнчлэн Компанийн нийгмийн хариуцлагын чиглэлээр сургалтыг GIZ-тай хамтран зохион байгуулсан. Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилт дэмжлэг туслахаагайгаар Компанийн засаглалтай холбогдох хууль, дүрэм журмын эмхтгэлийг боловсруулж мэргэжлийн байгууллага, хувьцаат компани, төрийн өмчит компаниудад хүргүүлэн ажиллалаа. Компанийн засаглалын кодекс шинэчлэн баталж, Монголын хөрөнгийн биржийн “А” самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниудад кодексийг хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг өгч үүнтэй холбогдуулан 10 удаагийн сургалтаар хувийн хэвшлийн 300 гаруй хүнийг оролцууллаа. Мөн “Компанийн засаглалын гэрчилгээ” олгох 36 цагийн сургалтад компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулан 2014 онд нийт 14 удаагийн сургалтаар 339 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарт гэрчилгээ олгосон байна. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-аар хувьцаат компанийн хүлээсэн үүргийн биелэлт 2014 оны дараах байдалтай байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компани 153 буюу нийт компанийн 48.8 хувь, санхүүгийн тайлангаа ирүүлсэн компани 197 буюу 62.9 хувь, Компанийн дүрмээ шинэчлэн баталсан компани 163 буюу 52.1 хувь, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгосон компани 175 буюу нийт компанийн 55.9 хувийг тус тус эзлэж байна.</p> |
|--|--|--|--|---|

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

2014 оны жилийн эцсийн байдлаар

| Д/д                         | Тогтоол шийдвэрийн огноо, дугаар, нэр  | Заалтын дугаар, агуулга   | Биелэлт   | Хувь      |
|-----------------------------|--|---|---|-----------|
| 1                           | УИХ-ын тогтоол 2013.05.24. Дугаар 39<br><br>Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай | 1.10. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | <p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төслийг Засгийн газраар УИХ-д өргөн бариулахтай холбогдуулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулга хийж, улмаар уг хуралдаанаар Сангийн ямаар дамжуулан УИХ-д хуулийн төслийг өргөн бариулах шийдвэр гарснаар мөн оны 10 дугаар сарын 07-ны өдөр хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төслийг Засгийн газарт өргөн барьсантай холбогдуулан 2014 оны 3 дугаар сарын 28-нд яамдаас ирсэн санал, хуулийн төсөл дээр дахин ажиллаж холбогдох саналыг 2014 оны 5 дугаар сарын 19-нд тус тус хүргүүлсэн. Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 17-ны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэн санхүүгийн түрээс, ломбард, валютын арилжааны талаарх олон улсын судалгааг ирүүлэхийг үүрэг болгосны дагуу холбогдох судалгааг хийж хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.</p> | 80        |
| <b>НИЙТ БИЕЛЭЛТИЙН ХУВЬ</b> |  |   |   | <b>80</b> |

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2014 оны жилийн эцсийн байдлаар

| Д/Д | Тогтоол шийдвэрийн огноо, дугаар   | Заалтын дугаар, агуулга   | Биелэлт   | Хувь |
|-----|--|---|---|------|
| 1   | <p><b>УИХ-ын тогтоол 2013.11.14. Дугаар 62</b><br/>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай</p> | <p><b>Тогтоолын: 3.1.</b> Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр 2014-2016 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, Монгол Улсын Их хуралд өргөн мэдүүлэх</p> <p><b>3.2.</b> Эдийн засгийн бодит салбарын идэвхжлийг дэмжих зорилгоор “Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх</p> | <p>“Монгол улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хороонд хүргүүлсэн. Тус хөтөлбөрт Монгол улсын санхүүгийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг салбар тус бүрээр 2020 он хүртэл тооцож дүнг нэгтгэн боловсруулсан.</p> <p>Сангийн сайд, Эдийн Засгийн хөгжлийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны хамтарсан 2014 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн А/137/67/187 /232 тушаалаар “Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөр батлагдсан. Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байна.</p>   | 80   |
|     | <p><b>3.3.</b> Бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжиж ажиллах</p>   |   | <p>Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлийн батлан даалтыг гаргаж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. Батлан даалтын хугацааны хувьд зээлдэгч болон банк, санхүүгийн байгууллага хооронд байгуулсан зээлийн гэрээний хугацаанаас хэтрэхгүй байхаар тогтоосон. Сан нь 2014 онд 269 иргэн, хуулийн этгээдийн 41.7 тэрбум төгрөгийн зээлд 17.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаар 1978 ажлын байр хадгалагдаж, 896 ажлын байр шинээр нэмэгдэх боломжийг бүрдүүлээд байгаа бөгөөд арилжааны 8 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж байна. 2014 онд гаргасан батлан даалтын 61 хувь буюу 165 нь Улаанбаатар хотод, 39 хувь буюу 104 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, иргэд байна. Батлан даалтын</p> | 100  |

|  |   |   |  |
|--|---|---|--|
|  | <p><b>3.4.</b>Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах</p>   | <p>үйлчилгээнд хамрагдсан харилцагчдын 52 хувийг үйлдвэрлэл, 15 хувийг хөдөө аж ахуй, 33 хувийг худалдаа үйлчилгээ эрхлэгчид тус тус эзэлж байна.</p> <p>Валютын үйл ажиллагаанд зохицуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлэхтэй холбоотой валютын захын талаар олон улсын практикыг судалж, судалгаан дээр үндэслэн валютын биржийн үйл ажиллагааны талаарх ойлголт, түүний бүтэц, зохион байгуулалт, хяналт зохицуулалтын талаар судлан, тус Хорооноос тусгай зөвшөөрөл авсан Банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа болон своп, форвард хэлцэлд оролцуулах, Монголбанкны үнэт цаас худалдан авах, бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг ББСБ-уудаар дамжуулан зээлдүүлэх талаар санал боловруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу Хороо болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны төлөөлөл бүхий хамтарсан 2 ажлын хэсэг байгуулагдан санал дүгнэлт гаргах чиглэлээр хамтран ажилласны үр днд Худалдаа Хөгжлийн Банк, Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо болон валютын арилжааны эрхтэй Банк бус санхүүгийн байгууллагууд /ББСБ/ хамтран “Хамтын ажиллагааны гурван талт” гэрээ байгуулсан. Үүний үр дүнд ББСБ-ууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн оролцох боломжтой болсон.</p> | <p style="text-align: right;"><b>100</b></p> |
|  | <p><b>3.5.</b>Валютын захад банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдыг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэлийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны тогтолцоог бий болгох</p> | <p>Валютын арилжааны мэдээг 104 банк бус санхүүгийн байгууллагуудаас /ББСБ/ улирал бүр авч байгаа ба мэдээний ирц 71.15 хувьтай байна. Арилжааны мэдээг нэгтгэн Монголбанкинд 2 удаа хүргүүлээ. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ болон тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй давхардсан тоогоор нийт 78 иргэн, хуулийн этгээдэд газар дээрх үзлэгийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын Газар, Цагдаагийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох мэдэгдлийг хүргүүлж, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсан 10 иргэнд захиргааны арга хэмжээ авсан. Үзлэг шалгалтын</p>   | <p style="text-align: right;"><b>100</b></p> |

|                                    |  |   |                    |
|------------------------------------|--|---|--------------------|
|                                    | <p><b>3.6.</b> Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээллэх арга хэмжээ авч ажиллах</p> <p><b>3.2.</b> Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагагай хамтран эхлүүлнэ.</p> | <p>ҮР дүнд Чингэлтэй дүүргийн Төмөрчний гудамжид тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсан нийт 30 гаруй иргэн дангаараа болон хамтран хуулийн этгээд байгуулан банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг аваад байна. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй 75 банк бус санхүүгийн байгууллагад шинээр нэвтрүүлэх санхүүгийн програмын талаарх сургалтыг “ИТАУКО” ХХК-тай хамтран хийсэн.</p> <p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013 оны 4 дүгээр улирал, 2014 оны 1,2,3 дугаар улирлын тайланг Сангийн яам, Монголбанктэй хамтран гаргалаа. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар Хорооны зүгээс банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны валютын дуудлага худалдаанд оролцуулах, гадаад валютын своп, форвард хэлцэл байгуулах, үнэт цаас худалдан авах үйл ажиллагаанд хамруулах, бичил санхүүгийн зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд хамруулах гэсэн 4 асуудал оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.</p> <p>"Иргэдийн санхүүгийн боловсролын хөтөлбөр" боловсруулах ажлын хэсэг байгуулан хөрөнгийн зах зээл, бичил санхүүгийн зах зээл, даатгалын зах зээлд оролцох санхүүгийн боловсрол олгох чиглэлээр хийгдэж байсан сургалт, семинар, хэлэлцүүлэг зэрэг зохион байгуулж байсан арга хэмжээнүүдийн талаарх судалгааг гарган хөтөлбөрийг боловсруулж эхлээд байна. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар Орос, Хонконг улсуудын зохицуулагч байгууллагуудын туршлагыг судалж байна. Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор "Саятан болох дамжаа" 26 ангит уран сайхны кино хийлээ.</p> | <p><b>100</b></p>  |
| <p><b>НИЙТ БИЕЛЭЛТИЙН ХУВЬ</b></p> |  |   | <p><b>94.2</b></p> |

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
БИЕЛЭЛТ**

2014 оны жилийн эцсийн байдлаар

| Д/д                         | Баримт бичгийн нэр, огноо, дугаар   | Заалтын дугаар, агуулга  | Биелэлт   | Хувь       |
|-----------------------------|---|--|---|------------|
|                             | УИХ-ын тогтоол 2014.06.05. Дугаар 41  | 6.Хөрөнгийн зах зээлийг дэмжих бодлогын хүрээнд Засгийн газрын урт хугацаат өрийн хэрэгслийг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах арга хэмжээг авах; | Монголбанкнаар дамжин арилжаалагдаж байгаа Засгийн газрын үнэт цаасны арилжааг хөрөнгийн зах зээл рүү хандуулах зорилгоор “МХБ” ХХК-аар дамжуулан арилжаалж эхэлсэн. Засгийн газар, орон нутгийн болон компанийн өрийн хэрэгслийг Хөрөнгийн биржээр арилжаалах арга хэмжээний хүрээнд Хорооны 2014 оны “Засгийн газрын үнэт цаасыг бүртгэх тухай” 389 дүгээр тогтоолоор дотоодын үнэт цаасны зах зээл дээр нийтэд санал болгон гаргах нийт 100,0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Засгийн газрын өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн. Энэхүү үнэт цаас нь 11 сарын 04-ний өдрөөс эхлэн хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхлээд байгаа ба 11 сард 4 удаагийн арилжаагаар нийт 28 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын өрийн хэрэгсэл арилжаалагдаад байна.   | <b>100</b> |
|                             | 7.Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааг Хөрөнгийн биржээр арилжаалах ажлыг 2013 онд багтаан зохион байгуулах |  | Уг үүргийг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хамтран ажиллах саналыг Уул уурхайн яам, Төрийн өмчийн хороонд тус тус 2013 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/271 тоогоор хүргүүлсэн боловч уг ажил хийгдэхгүй өнөөг хүрээд байна. Хуулийн дээрх зохицуулалт 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад шинээр хуульчлагдсан боловч өнөөг хүртэл уг хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий байгууллагууд болох Эрдэс баялаг, эрчим хүчний яам /хуучнаар/, Уул уурхайн яам, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар болон Төрийн өмчийн хороо зэрэг холбогдох байгууллагууд руу удаа дараа хуулийн дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналыг гаргаж ажиллаж ирсэн боловч уг ажлын үр дүн хангалтгүй байна. Харин стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК-иуд нь Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байдаг бол “Эрдэнэс Тавантолгой” компани нь хувьцаагаа тус Хороонд бүртгүүлэхээр ажиллаж байгаа болно. | <b>50</b>  |
| <b>НИЙТ БИЕЛЭЛТИЙН ХУВЬ</b> |   |  |   | <b>75</b>  |

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГӨГДСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2014 оны жилийн эцсийн байдлаар

| Баримт бичгийн нэр, огноо, дугаар   | Заалтын дугаар, агуулга   | Биелэлт   | Хувь                             |
|---|---|---|----------------------------------|
| <p align="center"><b>УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл 2013.12.10. Дугаар 30</b></p> <p align="center">Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хороонд шалгасан дүн</p> | <p>1. Санхүүгийн зах зээлийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөлтэй Хорооны зүгээс хамтран ажиллах механизмыг шинэчлэн сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийн үр өгөөжтэй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад бодитой оролцох оролцоог нь хангасан хэлбэрийг бий болгон хөгжүүлэх</p> <p>2. Санхүүгийн секторын шинэтгэлийг эрчимтэй үргэлжлүүлэх чиглэлээрх Хорооны санаачилгыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд үүссэн 95:5 гэсэн зохистой бус харьцааг өөрчлөх талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд Хорооны оролцоог идэвхжүүлэх</p> <p>3. Хувьцааны хэт төвлөрөл явагдсан, Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд нь жинхэнэ утгаараа хувьцааг компани болж ажиллаж чадаагүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төдийлөн сайн хамгаалж чадахгүй байгаагийн улмаас үнэт цаасны зах зээл зогсонги</p> | <p>Санхүүгийн Зохицуулах Хороо нь төрийн болон төрийн бус байгуулага, салбарын мэргэжлийн холбоод нийт 29 байгууллагатай “Санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Үүнээс гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 5 байгууллага, Монгол Улсын төрийн 8 байгууллага, 9 мэргэжлийн холбоод, 5 Төрийн бус байгууллага, 1 хэвлэл мэдээллийн байгууллагатай “Санамж бичиг”-ийн хүрээнд хамтран ажиллалаа. 2014 онд Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Албан журмын даатгагчдын холбоо, “Эрдэм мэдлэг түгээх төв” Төрийн бус байгууллагатай шинээр, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн нэгдсэн холбоо, Хөдөө аж ахуйн биржийн зохицуулах зөвлөлтэй гурван талт, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг” –ийн шинээр буюу шинэчлэн байгуулсан.</p> <p>Монгол улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлээд байна.</p> | <p align="center"><b>100</b></p> |
|   |   |   | <p align="center"><b>100</b></p> |
|   |   | <p>Үнэт цаасны арилжааг нь зогсоосон нэр бүхий 36 хувьцааг компанийн удирдлагад тус Хорооноос хувьцааны арилжааг сэргээх, нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааны төвлөрлийг сааруулах, эсхүл үнэт цаасны бүртгэлээс хасуулах зэрэг хэлбэрийн аль нэгийг сонгон асуудлаа шийдвэрлэх хугацаатай үүргийг өгөөд байна. Ингэснээр Хөрөнгийн бирж дээр бүртгэлийн шаардлага хангахуйц цөөн, томоохон компаниуд үлдэх юм. Мөн түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хувьцааг компанийн хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан хийх асуудлыг ТӨХ-</p>  | <p align="center"><b>100</b></p> |

|  |   |             |
|--|---|-------------|
|  | байдалд орсонд дүгнэлт хийж үнэг цаасны зах зээлийг идэвхжүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх   | нд тавьсан. |
| <p>4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг алслагдмал орон нутгийн иргэдэд хүргэх хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгааг анхааралдаа авч, тэдгээрийн үйлчилгээний хүрээг тэлэх, зохицуулалтын оновчтой бодлого боловсруулж, орон нутагт тохирсон банк бус санхүүгийн үйлчилгээний шинэ загвар бүтээгдхүүн нэвтрүүлэх, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга механизмыг сайжруулах, Төв банктэй энэ чиглэлээр хамтран ажиллах</p> | <p>Орон нутгийн иргэдэд хүргэх санхүүгийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн доод хэмжээг шинэчлэн тогтоохдоо аймгийн төвийн сумаас бусад суманд зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол дүрмийн сангийн хэмжээ 20,0 сая төгрөг, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга, итгэлцэл зэрэг үйл ажиллагаа эрхлэх бол дүрмийн сангийн хэмжээ 50,0 сая төгрөг, аймгийн төвийн сумдад 50.0 сая төгрөг, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга, итгэлцэл зэрэг үйл ажиллагаа эрхлэх бол дүрмийн сангийн хэмжээ 100.0 сая төгрөг байхаар ялгавартайгаар тогтоосон. Цаашид банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төсөл батлагдахтай холбогдуулан бичил санхүүгийн шинэ бүтээгдхүүн үйлчилгээг орон нутагт бүрэн нэвтрүүлэх боломжтой болно.</p>  | 100         |
| <p>5. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр валютын биржийн тогтолцооны талаарх асуудлыг хэлэлцүүлж, валютын үйл ажиллагаанд зохицуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох, 2014 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлтэй уялдуулах</p>   | <p>Банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа болон своп, форвард хэлцэлд оролцуулах, Монголбанкны үнэт цаас худалдан авах талаар санал боловсруулан Тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу Хороо болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны төлөөлөл бүхий хамтарсан 2 ажлын хэсэг байгуулагдан санал дүгнэлт гаргах чиглэлээр хамтран ажилласны үр дүнд Худалдаа Хөгжлийн Банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон валютын арилжааны эрхтэй банк бус санхүүгийн байгууллагууд хамтран “Хамтын ажиллагааны гурван талт” гэрээ байгуулсан. Үүний үр дүнд банк бус санхүүгийн байгууллагууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн оролцох боломжтой болсон. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй 75 банк бус санхүүгийн байгууллагад шинээр нэвтрүүлэх санхүүгийн програмын талаарх сургалтыг “ИТАУКО” ХХК-тай хамтран хийсэн.</p> | 100         |
| <p>6. Бичил санхүүгийн болон банк бус санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах, зээлийн хүүг бууруулах бодлогын</p>  | <p>Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоодын эрдэлийг бууруулах ажлын хүрээнд 2014 онд 378 банк бус санхүүгийн байгууллагын 322 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 178 банк бус санхүүгийн байгууллага, 52 Хадгаламж зээлийн хоршоо,</p>   | 100         |

|  |  |  |            |
|--|--|--|------------|
|  | <p>орчинг бий болгох</p> <p>7. Иргэд, даатгуулагчдын санхүүгийн болон даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, үндэсний давхар даатгалын компани байгуулах талаар судалгаа хийж, үндэслэл боловсруулах</p> | <p>Монголбанкны зээлийн мэдээллийн санд холбогдоод байна.</p> <p>Иргэд, даатгуулагчдын санхүүгийн болон даатгалын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор "Хүртэмжтэй даатгал 2014" Олон улсын чуулга уулзалт, "Даатгалын салбарын зохицуулалт" сэдэвт сургалт семинаруудыг 2014 онд зохион байгуулсан. Давхар даатгалын талаар судалгаа хийсэн бөгөөд холбогдох зохицуулалт нь 2014 оны 6 сарын 13-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар батлагдсан Малын индексжүүлсэн даатгалын хуулинд тусгагдсан.</p> | <p>100</p> |
|--|--|--|------------|

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО